

Herbalife<sup>®</sup>

# President's Team-д тавтай морилно уу!

President's Team хэмээх нэр хүндтэй статуст хүрсэнд тань баяр хүргэе! President's Team-ийн статусын болзлыг биелүүлсний дараа таны энэхүү амжилтыг сайшаах олон олон гайхалтай мөчүүдийн нэг бол компанийн бүс нутаг хариуцсан ерөнхийлөгч болон удирдлагын багийнхантай хийх дуудлага байх бөгөөд түүгээр бид таны түүхийг ярилцах болно.

Таны манлайллын дараагийн алхам бол Лос Анжелес хотноо болох шинэ President's Team-ийн гишүүдэд зориулсан Лидерүүдийн арга хэмжээнд оролцох явдал билээ. Энэхүү онцгой арга хэмжээнд оролцох таны бүх зардлыг компани даах бөгөөд таныг онцгой бэлэг, Founder's Circle эсвэл Chairman's Club-ийн гишүүдийн мастер класс сургалт, Гүйцэтгэх захирал Стефан Грацианитай Сайшаалын үдэш мөн өөр олон сайхан зүйлс хүлээж байна.\* Таныг VIP зочин хэмээн хүлээж авах тул үүнд бэлэн байгаарай.

Компанийн суурин оффисын ажилтан тантай холбогдож, сургалтын өдрийн талаар мэдээлэл хүргэх болно.



## Таныг VIP зочин хэмээн хүлээж авах тул үүнд бэлэн байгаарай.

### Онцгой хөтөлбөр:

- Лос Анжелес хот руу очих ба буцах нислэгийн тийз (эконом-класс)
- Арга хэмжээ болох зочид буудалд байрлах
- Нисэх буудлаас угтаж авах/үдэж өгөх унаагаар үйлчлэх
- Тусгай хүлээн авалт
- Лейк Форест дахь H.I.M.-р зочлох
- Компанийн эксперт ба удирдлагын багийн панель ярилцлага
- Founder's Circle эсвэл Chairman's Club-ийн гишүүдийн мастер класс сургалт ба асуулт хариултын хэсэг
- Herbalife-ын фитнес эксперттэй хамт дасгал хийх
- LA Live-ийн толгой оффист таны гайхам амжилтыг сайшаах арга хэмжээ
- President's Team-ийн шинэ гишүүдэд зориулсан онцгой бэлэг



\*Herbalife нь арга хэмжээний тасалдал, хойшлолт, цуцлалт, өөрчлөлтөд хариуцлага хүлээхгүй. Herbalife нь энэхүү арга хэмжээний аль ч хэсгийг өөрийн үзэмжээр өөрчлөх, өргөжүүлэх, хасах эсвэл солих эрхтэй.

# Калифорни мужийн Лос Анжелес хотод хүрэх зам!

**President's Team-ийн шинэ гишүүдэд зориулсан Лидерүүдийн арга хэмжээнд оролцох 3 арга:**

President's Team-ийн шинэ гишүүдэд зориулсан энэхүү арга хэмжээнд оролцохын тулд President's Team-ийн шинэ гишүүд дараах болзлын аль нэгийг биелүүлэх шаардлагатай:

1. Та President's Team-ийн болзлоо биелүүлэхээс өмнөх дурын нэг сард 7500 ба түүнээс дээш Үйлчилгээ үзүүлсэн урамшууллын оноо хийгээрэй.
2. Хүлээлгийн хугацаа дууссаны дараа анх удаа 6%-ийн Борлуулалтын урамшууллаа аваарай.
3. 1 Бриллиант – та доод багийнхаа аль нэг эгнээнд President's Team-ийн 1 шинэ гишүүнтэй болоорой.



## Дүрэм:

- Болзлыг зөвхөн Herbalife баталгаажуулах боломжтой.
- Арга хэмжээний оролцогчид ёс зүйн зөрчилгүй байх ёстой. Гишүүнийг өмнө гаргасан зөрчил эсвэл одоо явагдаж буй ёс зүйн шалгалтын улмаас оролцуулахгүй байж болно.
- Herbalife нь арга хэмжээ болох өдөр хүртэл гишүүний болзлыг дахин шалгаж, баталгаажуулах эрхтэй.
- Паспорт, виз, иргэншил баталгаажуулах бусад бичиг баримт болон арга хэмжээ болох улсад нэвтрэх/аялах шаардлагатай бусад бичиг баримт бүрдүүлэлтийг Herbalife бус, харин Бие даасан гишүүд өөрсдөө хариуцна.
- Бие даасан гишүүд нь President's Team-ийн шинэ гишүүдэд зориулсан Лидерүүдийн арга хэмжээнд оролцохтой холбоотой бүх татвар төлөлтийг бүрэн хариуцна (шаардлагатай тохиолдолд).
- Болзол/шагнал урамшуулал зэргийг тухайн Бие даасан гишүүний (ID) амжилтад үндэслэн олгоно.
- Гэр бүл цуцлуулах үйл явцын үр дүнд тусдаа гэрээ байгуулсан хэдий ч үндсэн гэрээний ID дугаар дээр болзол биелүүлсэн бие даасан гишүүд нь аяллын болон байрны зардлын 50%-ийг хариуцна.
- Шаардлагатай тохиолдолд болзлыг баталгаажуулсан оноонд үндэслэж тооцно.
- President's Team-ийн шинэ гишүүдэд зориулсан Лидерүүдийн арга хэмжээ бол болзлоо биелүүлсэн Бие даасан гишүүн Лос Анжелес хотод эхнэр/нөхөр эсвэл зочинтойгоо биечлэн оролцох нэг удаагийн боломж юм. Хэрэв бие даасан гишүүн энэ арга хэмжээнд ганцаараа оролцохоор шийдсэн бол түүний эхнэр/нөхөр эсвэл зочин ирээдүйд өөр ийм төрлийн арга хэмжээнд оролцох боломжгүй юм. Бие даасан гишүүний гэрээ эзэмшигч нь арга хэмжээнд өөрөө оролцох ёстой. Гэрээний үндсэн эзэмшигч өөрөө оролцоогүй тохиолдолд түүний эхнэр/нөхөр эсвэл зочид оролцох боломжгүй юм.
- Арга хэмжээний хөтөлбөрт төлөвлөсөн үйл ажиллагаанаас гадуурх аливаа зардлыг, тухайлбал, нислэгийн ангилал өөрчлөх, өрөөгөө солих болон зочид буудлын нэмэлт зардал зэргийг Бие даасан гишүүн өөрөө хариуцна.
- Зочид буудалд бүртгүүлэхийн тулд Бие даасан гишүүд хүчинтэй бичиг баримт болон гэнэтийн хэрэгцээнд ашиглаж болох банкны карттай байх ёстой.